

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН

Малаян бэрхийн тайлбар зохиолын рашааны тухайд хийсэн эх бичгүүдийн харьцуулсан судалгаа

Билэгсайхан Б.¹, Золзаяа Б.², Буянт Б.³, Болдсайхан Б.⁴

¹Өвөр Монголын Үндэсний Их сургууль

²"Оточ Манрамба" Их сургууль

³Монгол Эм Эмнэлгийн Дээд сургууль, ТонгЛиiao хот

⁴Нэгтгэмэл Анагаах Ухааны Монголын сэтгүүл

e-mail: biligsaikhan.21@gmail.com

Abstract

A comparative study of the original articles about the springs in the explanatory literature on the Ma la ya'i mystery

Bilegsaikhan B.¹, Zolzaya B.², Buyant B.³, Boldsaikhan B.

¹Inner Mongolia National University

²University of "Otoch Manramba"

³China Traditional Mongolian Medicine University, Tongliao City

⁴Mongolian Journal of Integrated Medicine

e-mail: biligsaikhan.21@gmail.com

Introduction

There is a sutra named "Detail explanatory of Ma la ya'i mystery and the giver everything wanted" (Ma la ya'i dka' 'grel 'dod pa 'jo ba) written by Mi'i nyi ma mthong ba don ldan, a Tibetan, which is considered as one of the undisputed ancient articles of Indian and Tibetan Medicines and to which Mongolian medical researchers in Mongolia and in Inner Mongolia, China haven't paid attention yet, so it is still not included in the scope of medical research work until now.

The sutra has an advantage that the place where the spring comes out is written in detail. Therefore, we now should thoroughly analyze the source place and features of the springs in order to convey a clear orderly understanding to future scholars by summarizing the research aligning it with traditional medical theory, and schematically mapping.

Goal

To make clearer the scholars' views of the four mountains included in the book "Rsta b'ai rgyud" and its theoretical and other concepts, as well as to analyze and conclude the interrelationships and features of springs in Ma la ya'i mountain.

Materials and Methods

In this research, I have studied the theory of Four mountains included in the book "Rsta b'ai rgyud" using the analyzing methods for original and source documents and summarized by the method of analysis and synthesis, as well as chosen the literature named "Detail explanation of Ma la ya'i mystery and the giver everything wanted" by sampling method and shown making sketch for the interrelations and features of springs by Hermeneutic method.

Results

As described by a person named Gyutog yontan mgonpo (Gyutog yontan mgonpo) in terms of Foreign, Domestic and Secret Medicine Palaces, and according to the relevant sutras and mantras that said

about them, the springs have the ability to heal diseases with the participation of earth directions, flora and fauna around the mountain and other factors. The sketch was clearly shown for the springs.

Conclusion

I believe that the debates about the Medicine Palace are highly dependent on the chronology in which the researchers lived and their own traditional ways. Currently, the five explanatory manuscripts written through XII - XX centuries about Medicine Palaces and Springs in Ma la ya'i Mountain have been found, among which, specially, the section written about the springs in the sutra named "Detail explanatory of Ma la ya'i mystery and the giver everything wanted" is a big thick book that was made at the level of "Great Explanation" in terms of its content. Therefore, I consider that this literature has become a new cognitive valuables added to the modern research resource because the knowledge of springs was presented greatly in depth and detail in this paper work.

Keywords: Malaya mountain, Foreign, domestic, secret medicine palace, springs and Medicine palace, a comparative study

Pp. 30-34, Table 1, Figures 5, References 14

Үндэслэл

Анагаах ухааны гол тулгуур, гүн оньсны ёс, шимийн дээдийг хураангуйлж номлосон

“Цог төгөлдөр дөрвөн үндэс” нь бүхнээ ялагч отчоос хутагт Нагаржунай, багш Даян, Качийн Дава Онга, Банчин Зандарадаваа, Лозава Бэрозана, хоёрдугаар бурхан

Бадамжунай, Дава Оншэй, Ютог Ёндонгомбо тэргүүтэнд уламжлагдан манай Дээд Монголын зүүн цаст цагаан уул хийгээд баруун цаст уулсын Төвөд оронд хоцролгүй дэлгэрчээ [1]. Энэ агуу бүтээлийг дэлгэрсэн цагаас нь эхлээд Монгол, Төвөдийн тэжээхүй ухааны мэргэд тайлбар, тайлал хийж ирсэн. Ялангуяа 13-16 дугаар зууны үеийн тайлбар номууд нь нэг талаас ховор, нөгөө талаас монгол хэлээр орчуулагдан судлагдаагүй байна. Ийм бүтээлийн нэг нь Малая хэмээх ууланд зургаан сайн эм, таван зүйлийн жонш, таван зүйлийн барагшин, таван зүйлийн эмт рашаан, таван зүйлийн халуун рашааны тухай тайлбар зохиол юм. Ялангуяа 5 зүйлийн хүйтэн, 5 зүйлийн халуун рашааны тухай тайлбар бичсэн Төвөдийн Мийнима Тонвадондангийн (Mi'i nyi ma mthong ba don ldan) бичсэн “Малаяан бэрхийн тайлбар, хүссэнийг саагч” (Ma la ya'i dka' 'grel 'dod pa 'jo ba) [2, 3, 4, 5] нэртэй судрын судалгаа Монгол Улс болон БНХАУ-ын ӨМӨЗО-ы монгол эмнэлгийн судлаачдын анхааралд бага өртөж, судалгааны хүрээнд оролгүй байсаар байна. Тиймээс уг судрын агуулгыг нь задлан шинжилж, нэгтгэн

дүгнэн, уламжлалт анагаах ухааны онолын талаас авч үзэхээр энэхүү судалгааг явууллаа.

Зорилго

“Язгуурын үндэс”-т дурдсан дөрвөн уулын тухай [6] эрдэмтэн мэргэдийн үзэл баримтлал, онол хийгээд ойлголтыг тодруулж, Малая уулын рашааны талаарх хоорондын уялдаа холбоо, онцлогийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх.

Зорилт:

1. “Язгуурын үндэс”-ийн дөрвөн уулын талаарх эрдэмтэн мэргэдийн үзэл баримтлалыг тодруулах.
2. “Язгуурын үндэс”-ийн дөрвөн уулын талаарх онол хийгээд ойлголтуудыг тодруулах.
3. Малая уулын рашааны талаар дэлгэрэнгүй бичсэн “Малаяан бэрхийн тайлбар, хүссэнийг саагч” зохиолыг сонгон авч рашаануудын мөн чанар, онцлог, ойлголтыг задлан шинжилж зураглан дүгнэх.

Материал, арга зүй

Судалгаандаа Эх бичиг, сурвалж бичиг судлалын аргаар Язгуур үндсийн дөрвөн уулын онол баримтлалыг, Анализ, синтезийн аргаар нэгтгэн дүгнэж, харьцуулан түүвэрлэлтийн аргаар “Малаяан бэрхийн тайлбар, хүссэнийг саагч” зохиолыг сонгон авч рашааны талаарх хоорондын улдаа холбоо, онцлог мөн чанарыг Герменевтикийн аргаар задлан шинжилж зураглан дүгнэв.

Үр дүн

Нэг. Язгуур үндсийн дөрвөн уулын талаарх эрдэмтэн мэргэдийн үзэл баримтлалыг тодруулах.

Язгуур үндсийн тайлбар зохиолуудад Эмийн хот балгад болон дөрвөн уулыг дэлхий дээр оршиж байгаа, байхгүй мөн дөрвөн уулыг нэг уул, эсвэл дөрвөн тусдаа уул байхаар мэргэдүүд хоорондоо мэтгэлцэн өөр өөрийнхөөрөө тайлбарласан байна. Энэ талаар тарнийн ёсны эмч нар энэ ертөнцийн “Очир сууринд,

Үржинхажидлингийн оронд, Одиян оронд” [7, 8,

9] байгаа уул хэмээн үзжээ. Мөн

“Цог төгөлдөр дөрвөн үндэс”-т тарнийн тухай өгүүлээгүй зарчмын дагуу Сүрхарва Лодойжалбо бээр тарнийн ёсоор бичигдсэн язгуур үндсийн талаарх тайлбаруудад хориг тавьсан харагдана. Анагаах ухааны судрын ёс болон тарнийн ёсыг хамтатган Ютог Ёндонгомбо (Gyutog yontan mgonpo) бээр Гадаад эмийн хот балгад, Дотоод эмийн хот балгад, Нууцын эмийн хот балгад хэмээн [10] нэрийдэж тайлбарласан нь хамгийн оновчтой бөгөөд хураангуй дэлгэр утгыг багтаасан байна.

Table 1. The following table shows the concepts of sutra and tantra of scholars of selected literature.

Names	View of the sutra	Veiv of the tantras	None them	of
Detail explanatory of Ma la ya'i mystery and the giver everything wanted		+		
Explanation for the Root thing, guiding cresset		+	+	
Khukh binderiya	+	+		
Meibo shallun	+			
Explanation of hidden meanings of the Root thing	+	+		

Хоёр. Язгуур үндсийн дөрвөн уулын талаарх онол хийгээд ойлголтуудыг тодруулах.

Буддын гүн ухааны логик арга зүй нь гадаад, дотоод, нууц гэсэн ойлголтоор эмийн хот балгадыг авч үзжээ. Үүнд Гадаад эмийн хот балгад нь дэлхийн соронзон орны агаар мандлыг, Дотоод эмийн хот балгад нь хүн, амьтан, ургамлыг, Нууц эмийн хот балгад нь амьд оршихууны дотоод гүн уялдааг арга билгийн онолд тулгуурлан тайларлажээ. Эдгээрийг Ютог Ёндонгомбын үзэл баримтлалын дагуу зураглан харуулбал илүү ойлгомжтой байхаар байна.




Figure 1. Brief introduction of foreign medicine palace




Figure 2. Brief introduction of domestic medicine palace




Figure 3. Brief introduction of secret medicine palace

Гурав. Малая уулын рашааны талаар дэлгэрэнгүй бичсэн “Малааян бэрхийн тайлбар, хүссэнийг саагч” зохиолыг сонгон авч рашаануудын мөн чанар, онцлог, ойлголтыг задлан шинжилж зураглан дүгнэх

Малааян бэрхийн тайлбарт хүйтэн рашааны хэсгийг хий, шар, бадган, хавсарсан, хурмалаар үндсэн 5 төрөл, ялгамжтай 104 төрөл рашааныг зүг чигээр нь баримжаалан авч үзсэн байна. Энэ нь гадаад үзэсгэлэнт эмийн хот балгадын дөрвөн зүг, найман зовхист ундрэн урсахдаа үйлдэл нөлөө өөр өөр болохыг өгүүлэх гэсэн хэрэг юм. Рашааны чадлыг зүгийн заалтаар халуун, хүйтэн өвчинд эрэмбэлэгдэн нөлөөлөх учиг үзүүр байгааг ийнхүү гадаад, дотоод хот балгадаар нь зураглаж харууллаа.

Халуун рашааны үндсэн таван ангиллын онцлог мөн чанараас шалтгаалж газарзүйн тогтоц нь тал газар, ой шугуй, хадан энгэр, хөндий гэх мэт газруудаас үүснэ гэж үзсэн.

Мөн халуун, хүйтэн рашааныг дээд, эрхэм, дунд, адаг гэсэн ангиллаар авч үзжээ. Рашааны дээд нь ихэвчлэн цул, савын өвчинд, эрхэм нь ихэвчлэн сав хийгээд тунгалаг, цусны өвчинд, дунд нь долоон тамирын өвчинд, адаг нь ихэвчлэн бүлх, шөрмөс, арьсны өвчнүүдийг эдгээнэ гэж үзсэн байна.

Халуун рашаан нь гол төлөв ерөнхий үйлдэл нөлөөгөөр их архаг өвчнүүдийг боловсруулж эдгээхэд чиглэгдсэн нь ажиглагдлаа. Хүйтэн рашаан нь ихэвчлэн ялгамжтай өвчнийг онож эмчлэхэд чиглэсэн гэж үзэхээр байна.




Figure 4. Detailed introduction of foreign spring medicine palace

HBSH: Healer Best for Shar, HGSh: Healer Good

for Shar, HBeSh: Healer Better for Shar, HBB: Healer Best for Badgan, HGB: Healer Good for Badgan, HBeB: Healer Better for Badgan, HSKh: Healer Satisfactory for Khii, HBeKh: Healer Better for Khii, HGKh: Healer Good for Khii, HBKh: Healer Best for Khii.




Figure 5. Detailed introduction of domestic spring medicine palace

Хэлцэмж

Язгуурын үндэс нь хураангуй ёсонд бичигдсэн. Түүний тайлбаруудад тусгагдсанаар Малая уулыг гадаад, дотоод, нууц гэсэн гурван логик арга зүйгээр хандсан байна.

Байгаль орчны зүг чиг, дөрвөн ууланд туссан нар сарны гэрлийн нөлөөгөөр ус ургамлын үйлдэл нөлөө нь өвчин эмгэгт өвөрмөцөөр нөлөөлөх эмчилгээний мөн чанарыг заасан байна.

“Язгуурын үндэс”, “Малая бэрхийн тайлбар, хүссэнийг саагч” “Мэбой шаллун” [11, 12], “Хөх биндэрьяа” [7, 8], “Язгуур үндсийн тайлбар тодруулагч зул” [13, 14], “Язгуур үндсийн далд утгын тайлбар” [9] эдгээр он цагийн дарааллаар бичигдсэн зохиолуудад Малая уулын эмт бодис, рашааны тайлбаруудыг харьцуулан үзлээ. Мийнима тонва дондангийн бүтээлийн намтарт тэмдэглэгдсэнээр “Малая бэрхийн тайлбар, хүссэнийг саагч их, бага” хэмээн дурджээ. Бидний харьцуулан үзсэнээр “Малая бэрхийн тайлбар, хүссэнийг саагч” нь “Их тайлбар”-ийг хийсэн нь тодорхой болж байна.

Дүгнэлт:

1. Эмийн хот балгадын талаарх мэтгэлцээнийг он цагийн дарааллаар авч үзвэл хамгийн эхэнд тайлбар хийсэн Ютог Ёндонгомбо

